



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/720

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа "Иргэдийн наадам" биеийн тамирын арга хэмжээнд зориулсан спортын уралдаан, тэмцээний зардалд 1500000 төгрөгийг хавсралтаар баталж дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд зарцуулагдах 1500000 төгрөг /нэг сая таван зуун мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.8 дахь "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
11 дүгээр сарын 24-ний өдрийн  
А/720 дугаар захирамжийн хавсралт



“ИРГЭДИЙН НААДАМ” БИЕИЙН ТАМИРЫН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Спортын төрөл / Медаль, цом/	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Олс таталт	28	10 000	280 000
2	Гар бөмбөг	54	10 000	540 000
3	Сагсан бөмбөг	48	10 000	480 000
4	Цом	4	50 000	200 000
Нийт дүн				1 500 000

-oOo-